


Долоо хоног тутмын мэдээ мэдээлэл - Монголын Мянганы сорилтын сан

№3 (4)

2021.05.03

БОАЖ-ЫН САЙД Н.УРТНАСАН: ЦЭНГЭГ УСЫГ 2030 ОН ГЭХЭД УУЛ УУРХАЙН ЗОРИУЛАЛТААР АШИГЛАХЫГ ХЯЗГААРЛАНА



УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаанаар БОАЖ-ын сайд Н.Уртнасан Усны нөөц, ашиглалтын өнөөгийн байдал, авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаарх мэдээллийг танилцууллаа. Энэ үеэр улс орны чанартай, стратегийн томоохон бүтээн байгуулалтын төслийн тасралтгүй хэвийн үйл ажиллагааг найдвартай, хүртээмжтэй усаар цаг хугацаанд нь хангахын тулд эхний ээлжид нөөц нь тогтоогдсон газрын доорх усыг ашиглах; томоохон голууд дээр урсацын тохируулга хийж, олон зориулалттай усан цогцолбор байгуулах замаар усны нөөцийг хуримтлуулан нөөцлөх, усан санг говь, тал хээрийн ууршил ихтэй бүсэд нөөцлөх, ус дамжуулах далд систем барьж байгуулах; говь, хээрийн бүсийн газрын доорх цэнгэг усны ордуудыг улсын тусгай хамгаалалтад авах, цэнгэг усыг 2030 он гэхэд уул уурхайн зориулалтаар ашиглахыг хязгаарлах, усны сан бүхий газрын хамгаалалтын бүсийн дэглэмийг хатуу мөрдүүлэх замаар усны нөөцийг бохирдох, хомстохоос сэргийлэх; хүн амыг чанарын шаардлага хангасан, баталгаатай ундны усны эх үүсвэрээр хангах зорилтын хүрээнд 2024 он хүртэл жил бүр 5 сумын төвийн ус хангамжийн эх үүсвэрийг тогтоох хайгуул судалгааны ажилд шаардагдах төсвийг шийдвэрлэх; гидрогеологийн зураглалын ажлыг нийт нутаг дэвсгэрийн 18 хувьд хүргэж, усны нөөцийн хайгуул судалгааны ажлыг нэмэгдүүлэх, газрын доорх усны мониторингийн сүлжээг өргөжүүлэхээр төлөвлөж буйгаа танилцууллаа.

Эх сурвалж: Байгаль орчин, аялал жуулчлалын яам

АНУ-ЫН ЭЛЧИН САЙД ЭЛЧИН МАЙКЛ С. КЛЕЧЕСКИ: УЛААНБААТАР ХОТЫН УС ХАНГАМЖИЙГ 80 ХУВИАР НЭМЭГДҮҮЛЭХ ХӨТӨЛБӨР ХЭРЭГЖҮҮЛЖ БАЙНА



АНУ-аас Монгол Улсад суугаа Онц бөгөөд бүрэн эрхт Элчин сайд Майкл С.Клечески “Bloomberg Mongolia” телевизийн Ярилцах цаг хөтөлбөрийн зочноор уригдаж, хоёр улсын шинэ түвшинд хүрсэн харилцаа, хамтын ажиллагаа, тэр дундаа Монгол Улсын Засгийн газар болон АНУ-ын Мянганы сорилтын корпорацын хооронд байгуулсан Мянганы сорилтын хоёр дахь Компакт гэрээний хүрээнд хэрэгжүүлж буй Улаанбаатар хотын нийт ус хангамжийг нэмэгдүүлэх хөтөлбөрийн талаар, түүнчлэн АНУ-ын Ерөнхийлөгч Жо Байден бодлогын талаар дэлгэрэнгүй ярилцжээ. Ярилцлагыг [ЭНЭ ХОЛБООСО](#)ор үзэх боломжтой.

Эх сурвалж: Bloomberg TV Mongolia

Ш.МЯГМАР: 250 МЯНГАН МЕТР КУБЫН БАГТААМЖТАЙ ЦЭВЭРЛЭХ БАЙГУУЛАМЖ БАРЬЖ АШИГЛАЛТАД ОРУУЛНА



УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаанаар БОАЖ-ын сайд Н.Уртнасан мэдээлэл хийх үеэр Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Усны газрын дарга Ш.Мягмар “АНУ-аас 350 сая ам.долларын буцалтгүй тусламж үзүүлнэ. Энэ хүрээнд гурван том төсөл хэрэгжүүлнэ. Нэгдүгээрт, Улаанбаатар хотын ус хангамжийг газрын доорх ус ашиглан нэмэгдүүлнэ. Хоёрдугаарт, төв цэвэрлэх байгууламжаас гарсан бохир усыг гүн боловсруулалт хийж, цэвэршүүлэн дулааны цахилгаан станцын хөргөлтөд өгнө. Гуравдугаарт, Усны засаглалыг бэхжүүлнэ. БНХАУ-ын хөнгөлөлттэй зээлийн хүрээнд төв цэвэрлэх байгууламжийг шинэчилж байгаа. Энэ ажлын хүрээнд 250 мянган метр кубын багтаамжтай цэвэрлэх байгууламж барьж ашиглалтад оруулна. Усыг гүн боловсруулж, дулааны 3, 4 дүгээр цахилгаан станцын хөргөлтөд ашиглана. Ингэснээр хаягдал усыг цэвэрлэж эргүүлэн ашиглаж байгаа ажилд том дэвшил гарна гэж үзэж байгаа” гэв. [Эх сурвалж: ikon.mn, gogo.mn](#)

УС АШИГЛАГЧ АЖ АХУЙН НЭГЖҮҮД 2020 ОНД УСНЫ НӨӨЦ АШИГЛАСНЫ ТӨЛБӨРТ 45.1 ТЭРБУМ ТӨГРӨГИЙГ ОРОН НУТГИЙН ТӨСӨВТ ТӨВЛӨРҮҮЛСЭН

Байгаль орчин, аялал жуулчлалын яамны мэдээллээр ус ашиглагч аж ахуйн нэгжүүд 2019 онд усны нөөц ашигласны төлбөрт 46.7 тэрбум, 2020 онд 45.1 тэрбум төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн агаад үүний 90 гаруй хувийг уул уурхайн салбар дангаар бүрдүүлж байна. Усны нөөцийн төлбөрийн хувьд унд ахуйн хэрэглээ, хөдөө аж ахуйн ус хэрэглээ буюу нийт ус ашиглалтын 70%-ийг төлбөрөөс чөлөөлж байгаа бөгөөд орон нутагт төвлөрч байгаа усны нөөц ашиглалтын төлбөрийг хуульд заасан зориулалтын дагуу зарцуулахгүй байгаа нь усны үнэлэмжийг бууруулж, цаашид усны хэмнэлт, үр ашгийг сайжруулах, усны нөөцийн хомстол, бохирдлын асуудлыг шийдвэрлэхэд хөшүүрэг болж чадахгүй байна гэж үзэж байгаа аж. Иймд “Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх хүрээнд усны нөөц ашигласны төлбөрийг хэрэглээний хэмжээнээс хамааруулан 2030 он хүртэл үе шаттайгаар шатлан өсгөх зарчмаар тогтоох, төлбөрийн орлогын тодорхой хэсгийг улсын төсөвт төвлөрүүлэн дахин хуваарилж, улсын хэмжээнд усны зохистой менежментийг хэрэгжүүлэх эрх зүйн зохицуулалтыг бүрдүүлэхээр төлөвлөж байгаа аж.

Эх сурвалж: Байгаль орчин, аялал жуулчлалын яам

УСНЫ СЭДЭВТ ЦАХИМ ХУРЛУУД

БХБЯ, БОАЖЯ, НЗДТГ болон ШУТИС-ийн Барилга, архитектурын сургууль хамтран “Улаанбаатар Ус-Цэвэр Орчин 2021” сэдэвт эрдэм шинжилгээний бага хурлыг 2021 оны 5 дугаар сарын 5-ны өдөр цахимаар зохион байгуулах гэж байна. Холбогдох мэдээллийг erkhee9191@gmail.com хаягаар авах боломжтой. [Эх сурвалж: ШУТИС-ийн БАС](#)